



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/131

Ховд


Зарим үйл ажиллагааг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а”, “л”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Улсын онцгой комиссын 2020 оны 03 дугаар тогтоол, Ховд аймгийн Онцгой комиссын хурлын 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 14 дүгээр шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байгаатай холбогдуулан аливаа шашны үйл /Майдар эргэх, Муслиман шашны мөргөл үйлдэх, Христийн цуглаан хийх/, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдөр, Наурызын баяр зэрэг тэмдэглэлт өдрийг тохиолдуулан нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэн сурталчилж ажиллахыг сумдын Засаг дарга нар, Цагдаагийн газар /Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ